



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/60


Өмнөдэлгэр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сар шинийн баярыг тохиолдуулан улс, аймаг, сумын цолтой хүчит 128 бөхийн барилдааныг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсугай.

2.Сар шинийн барилдааныг зохион байгуулахад шаардагдах 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.



Р.ЭНХТӨР

